



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 23 өдөр

Дугаар A/265

Арвайхээр

Зөвлөл байгуулах тухай

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал, маягт шинэчлэн батлах тухай” A/220, A/475, A/812 дугаар хамтарсан тушаалын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бүх шатны боловсролын үйлчилгээнд холбон зуучлах үүрэг бүхий “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагчийн хүсэл, эрүүл мэндийн байдал, онцлогийг харгалзан боловсролын үйлчилгээнд хамруулж, холбогдох сургалтын арга хэлбэрийг сонгон, шаардлагатай эрүүл мэнд, нийгмийн халамж, сэргээн засах үйлчилгээнд холбон зуучилж ажиллахыг Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн дарга (Б.Сайнжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0567

Аймгийн Засаг даргын 2022 оны  
05 дугаар сарын 23-ны өдрийн  
11/205 дугаар захирамжийн  
хавсралт

**“БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТЫГ ДЭМЖИХ ЗӨВЛӨЛ”-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Зөвлөлийн дарга: Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Мөнх-Эрдэнэ (аймгийн Засаг даргын дэргэдэх  
Боловсрол, шинжлэх ухааны газрын тэгш хамран  
сургалт хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Д.Тогтохдулам (Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Хүүхдийн  
тасгийн эрхлэгч, зөвлөх эмч)

Х.Пүрэвсүрэн (Арвайхээр сумын ерөнхий боловсролын 2 дугаар  
сургуулийн тусгай бүлгийн согог зүйч багш)

Г.Зууннаст (Арвайхээр сумын ерөнхий боловсролын 5 дугаар  
сургуулийн захирал)

Б.Болормаа (Арвайхээр сумын 11 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч)

О.Эрдэнэцэцэг (аймгийн Насан туршийн боловсролын төвийн арга  
зүйч)

-оОо-